

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2026/064/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас:99422227 Цахим хаяг: aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: Р.Содномдаржаа

Утас: 99101563 Цахим хаяг: Uujimaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХҮҮХДИЙН
13 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ЖАНАРГУЛ ТАНАА

А026.02.04 № 113
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Өлгий сумын хүүхдийн 13 дугаар цэцэрлэг нь 2025 онд 1,253.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр ажиллаж, гүйцэтгэлээр 1,210.4 сая төгрөг зарцуулж, 96.5 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

830605000064

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.АЙГҮЛ



Өлгий сумын хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,253,919,100.00	1,210,401,632.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,253,919,100.00	1,210,401,632.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,253,919,100.00	1,210,401,632.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	945,082,100.00	915,291,566.13
210101	Үндсэн цалин	654,587,300.00	589,186,105.00
210102	Нэмэгдэл	264,889,900.00	256,482,144.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		25,703,611.00
210104	Урамшуулал	25,604,900.00	43,919,706.13
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	117,506,200.00	109,450,100.00
210201	Тэтгэврийн даатгал	79,702,900.00	74,433,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,450,800.00	8,757,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,725,400.00	4,380,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,725,400.00	4,380,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,901,700.00	17,498,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,102,000.00	97,102,000.00
210301	Гэрэл, цахилгаан	9,342,000.00	9,342,000.00
210302	Түлш, халаалт	26,260,000.00	26,260,000.00
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	2,500,000.00
210304	Байрны түрээс	59,000,000.00	59,000,000.00
2105	Нормативт зардал	70,439,300.00	65,675,700.00
210502	Хоол, хүнс	70,439,300.00	65,675,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,200,000.00	1,200,000.00
210604	Урсгал засвар	1,200,000.00	1,200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,241,600.00	2,363,366.56
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,241,600.00	2,363,366.56
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,347,900.00	19,318,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,359,000.00	13,330,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,988,900.00	5,988,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,253,919,100.00	1,078,482,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	984,944,400.00	980,180,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	984,944,400.00	980,180,800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	98,302,000.00	98,302,000.00
132001	Орон нутгийн төсвөөс	98,302,000.00	98,302,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	170,672,700.00	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	170,672,700.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		184,883,933.26
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,965,100.57
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42.00	42.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	23.00	23.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	45.00	42.00
650004	ССБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	20.00	18.00
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1.00	1.00
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1.00	1.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	23.00	22.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийг шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг долоо хоногийн дотор гэсэн заалтыг зөрчиж 40.5 сая төгрөгийн худалдан авалтын 3 шийдвэрийг, 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 140.1 сая төгрөгийн 11 мөнгөн гүйлгээг, цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 63.9 сая төгрөгийн зарлагын 10 мөнгөн гүйлгээг, Худалдан авах ажиллагааны тайлан 91.9 сая төгрөгийн 1 мөнгөн гүйлгээг тус тус шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй байна. Мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75.2 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 4.1.4-т “хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх”, 5 дугаар зүйлийн 5.1.4-т “мэдээллийг тогтмол шинэчилж байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 7 дугаар зүйлийн 7.1-д “Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ” гэсэн заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй 336.4 сая төгрөгийн 25 мэдээллийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг албан шаардлага болгов.

Аудитаар 189.3 сая төгрөгийн алдаа¹ илэрч, аудитын явцад 189.3 сая төгрөгийн алдааг залруулсан. Залруулсан алдаа:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд байр ашиглалттай холбоотой тогтмол зардалыг 3.2 сая төгрөгөөр илүү, нийгмийн даатгалын шимтгэлийг 3.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд улсын төсвөөс санхүүжих 4.8 сая төгрөгийн, урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийн 170.7 сая төгрөгийг тайлагнаагүй.
- Бараа материалын тайлангийн тодорүүлга тайланд түлш халаалтын дансны үлдэгдлийг 3.2 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Санхүүгийн байдлын тайланд цалингийн 2.4 сая төгрөгийн, ХХОАТ-ын 1.4 сая төгрөгийн авлагыг дутуу тайлагнасан.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Өлгий сумын хүүхдийн 13 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Энэ нь Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам, УСНББОУС 1 стандарт, толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд орлого, зардлыг зөрүүтэй тайлагнасан	1	6,937.7			1	6,937.7	1	6,937.7				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд орлогыг дутуу тайлагнасан	1	175,436.3	1	175,436.3			1	175,436.3				
Бараа материалын тайлангийн тодруулга тайланд үлдэгдлийг дутуу тайлагнасан	1	3,179.7	1	3,179.7			1	3,179.7				
Авлагыг дутуу тайлагнасан	1	3,757.4	1	3,757.4			1	3,757.4				
Дүн	4	189,311.3	3	182,373.6	1	6,937.7	4	189,311.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал		
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээ мэдээллийг оруулаагүй хэрэгжилт 75.2%-тай байна.	1	336,599.7			1	336,599.7		
Дүн	1	336,599.7			1	336,599.7		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								